



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Алдархаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **ЗАА-2022/01/СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: www.audit.mn Улиастай сум 2022 он</p>	<p>Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа Утас: 99993365 Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор Б.Дагвасүрэн Утас:99014227 Цахим хаяг: dagvasurenb@audit.gov.mn</p> <p>Аудитор Ц.Оюунсүвд Утас: 99076038 Цахим хаяг: oyunsuvdts@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал.....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал.....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
4. Аудитын илрүүлэлт.....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12

᠔᠔᠔᠔.᠐᠔.᠒5 № 13᠐᠗/378

танай _____ -ны № _____ -т

АЛДАРХААН СУМЫН
ЗАСАГ ДАРГА ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Д.ТӨМӨРХҮҮ-д

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Алдархаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Алдархаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

4.5 сая төгрөгийн шатахуун, 1.7 сая төгрөгийн албан томилолтын зардлын зарцуулалтын баримыг бүрэн бүрдүүлээгүй, эдгээр зардлыг үрэлгэн зарцуулсан, 4.9 сая төгрөгийн худалдан авалтын и-баримтыг бүрдүүлээгүй, улс төрийн албан хаагчид 2.9 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон, албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан ажлыг хавсран гүйцэтгүүлэхээр шийдвэр гаргаж, 0.6 сая төгрөгийн нэмэгдэл хөлс олгосон, өмнөх онд үүссэн 2.0 сая төгрөгийн түлш халаалтын өглөгийг барагдуулаагүй, тайлант онд 3.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 5.6 сая төгрөгийн өглөг үүсгэсэн, шүүхийн шийдвэрээр 14.3 сая төгрөгийн ажилгүй байсан хугацааны цалин олгосон зэрэг зөрчлүүд нь (Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.3; Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1, 57.2.1; Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5, Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2; Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3; Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.3, 1.5 дахь заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх зэрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй) байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Audit(D)A4-тоот/2022
01 11 2022

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй - бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>32,909,875.00</u>	<u>30,969,569.06</u>
33	АВЛАГА	-	26,794.06
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	26,794.06
35	БАРАА МАТЕРИАЛ	32,909,875.00	30,942,775.00
351	Түүхий эд материал	6,617,455.00	6,617,455.00
35110	Тусгай зориулалттай материал	6,617,455.00	6,617,455.00
354	Хангамжийн материал	25,292,420.00	24,325,320.00
35420	Аж ахуйн материал	19,631,820.00	18,664,720.00
35470	Бусад хангамжийн материал	5,660,600.00	5,660,600.00
35600	Мал амьтад	1,000,000.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>810,214,155.13</u>	<u>558,443,522.23</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	810,214,155.13	558,443,522.23
392	Биет хөрөнгө	779,535,455.13	528,094,822.23
39201	Барилга, байгууламж, орон сууц	917,217,482.48	741,464,226.48
39202	Хуримтлагдсан элэгдэл	(213,139,097.42)	(269,185,823.40)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	59,694,800.00	59,694,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(35,364,586.86)	(45,463,547.10)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	230,928,191.00	230,928,191.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(214,274,866.86)	(219,796,298.46)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	33,551,016.00	33,551,016.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(27,156,707.21)	(28,539,617.57)
39214	Бусад үндсэн хөрөнгө	34,148,638.00	34,148,638.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(6,783,869.00)	(9,421,217.72)
39217	Ном	714,455.00	714,455.00
393	Биет бус хөрөнгө	30,678,700.00	30,348,700.00
39301	Программ хангамж	2,602,000.00	2,602,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,144,500.00)	(1,474,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	29,221,200.00	29,221,200.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>843,124,030.13</u>	<u>589,413,091.29</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>2,006,264.05</u>	<u>5,584,192.53</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,006,264.05	5,584,192.53
413	Өглөг	2,006,264.05	5,584,192.53
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	2,006,264.05	5,584,192.53
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>841,117,766.08</u>	<u>583,828,898.76</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	841,117,766.08	583,828,898.76
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	448,989,594.69	448,989,594.69
51101	Өмч: - төрийн	448,989,594.69	448,989,594.69
512	Хуримтлагдсан үр дүн	145,713,561.85	70,081,585.33
51210	Өмнөх үеийн үр дүн	135,017,024.68	327,370,452.65
51220	Тайлант үеийн үр дүн	10,696,537.17	(257,288,867.32)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	246,414,609.54	64,757,718.74
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>843,124,030.13</u>	<u>589,413,091.29</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	438,908,435.88	538,222,805.02
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	58,555,752.88	160,131,948.02
120	Нийтлэг татварын бус орлого	58,555,752.88	160,131,948.02
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	58,555,752.88	160,131,948.02
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	58,555,752.88	160,131,948.02
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	380,352,683.00	378,090,857.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,945,583.00	25,561,257.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,945,583.00	25,561,257.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	373,407,100.00	352,529,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	352,907,100.00	352,529,600.00
132004	Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/	20,500,000.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	425,295,231.97	445,000,343.42
21	УРСГАЛ ЗАРДАЛ	425,295,231.97	445,000,343.42
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	387,265,083.50	411,755,161.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	217,113,671.03	211,579,117.18
210101	Үндсэн цалин	217,113,671.03	211,579,117.18
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,088,614.00	25,635,227.06
210201	Тэтгэврийн даатгал	18,476,003.00	17,856,497.66
210202	Тэтгэмжийн даатгал	2,173,647.00	2,001,752.94
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,725,477.00	1,587,585.92
210204	Ажилгүйдлийн даатгал	428,498.00	377,724.54
210205	Эрүүл мэндийн даатгал	4,284,989.00	3,811,666.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	51,183,664.05	52,755,328.48
210301	Гэрэл, цахилгаан	2,047,861.05	2,200,850.13
210302	Түлш, халаалт	49,135,803.00	50,554,478.35
2104	Хангамж, бараа материалын зардал	21,972,400.00	28,082,440.00
210401	Бичиг хэрэг	2,601,900.00	3,129,300.00
210402	Тээвэр, шатахуун	17,101,500.00	18,087,940.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,269,000.00	3,793,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	2,072,000.00
210408	Бараа материал акалсны зардал	-	1,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	455,500.00	2,199,300.00
210604	Урсгал засвар	455,500.00	2,199,300.00
2107	Томилолт, зочны зардал	3,630,100.00	2,807,500.00
210702	Дотоод албан томилолт	3,630,100.00	2,807,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,952,649.50	6,820,607.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,706,832.00	5,433,807.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	232,100.00	540,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	469,100.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	177,117.50	14,940.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	73,800.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	150,000.00	480,800.00

Алдархаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210807	Газрын төлбөр	138,300.00	351,060.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	5,400.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	58,868,484.92	81,875,642.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,798,571.00	12,720,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	2,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	51,069,913.92	69,153,642.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,030,148.47	33,245,181.70
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,878,900.00	25,602,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,878,900.00	25,602,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	14,151,248.47	7,643,181.70
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,151,248.47	7,643,181.70
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	13,613,203.91	93,222,461.60
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,916,666.74	350,511,328.92
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	2,916,666.74	342,748,938.92
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	7,762,390.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(2,916,666.74)	(350,511,328.92)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	10,696,537.17	(257,288,867.32)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	448,989,594.69	234,482,138.80	139,808,138.68	823,279,872.17
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-4,791,114.00	-4,791,114.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	448,989,594.69	234,482,138.80	135,017,024.68	818,488,758.17
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	11,932,470.74	0.00	11,932,470.74
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	10,696,537.17	10,696,537.17
C08	2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	448,989,594.69	246,414,609.54	145,713,561.85	841,117,766.08
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	448,989,594.69	246,414,609.54	145,713,561.85	841,117,766.08
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	448,989,594.69	246,414,609.54	145,713,561.85	841,117,766.08
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	181,656,890.80	181,656,890.80
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	448,989,594.69	246,414,609.54	327,370,452.65	1,022,774,656.88
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	181,656,890.80	0.00	-181,656,890.80
D09	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	897,979,189.38	311,172,328.28	654,740,905.30	1,863,892,422.96

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	380,352,683.00	378,090,857.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	380,352,683.00	378,090,857.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,945,583.00	25,561,257.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,945,583.00	25,561,257.00
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	373,407,100.00	352,529,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	352,907,100.00	352,529,600.00
132004	Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/	20,500,000.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	379,371,254.00	378,090,857.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	379,371,254.00	378,090,857.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	341,341,105.53	344,845,675.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	217,113,671.03	211,605,911.24
210101	Үндсэн цалин	216,813,671.03	211,605,911.24
210104	Урамшуулал	300,000.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,088,614.00	25,635,227.06
210201	Тэтгэврийн даатгал	18,476,003.00	17,856,497.66
210202	Тэтгэмжийн даатгал	2,173,647.00	2,001,752.94
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,725,477.00	1,587,585.92
210204	Ажилгүйдлийн даатгал	428,498.00	377,724.54
210205	Эрүүл мэндийн даатгал	4,284,989.00	3,811,666.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49,177,400.00	49,177,400.00
210301	Гэрэл, цахилгаан	2,047,861.05	2,226,035.27
210302	Түлш, халаалт	47,129,538.95	46,951,364.73
2104	Хангамж, бараа материалын зардал	21,704,320.00	25,166,840.00
210401	Бичиг хэрэг	2,817,500.00	2,828,300.00
210402	Тээвэр, шатахуун	16,503,820.00	18,087,940.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,383,000.00	4,250,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,058,600.00	2,792,800.00
210604	Урсгал засвар	1,058,600.00	2,792,800.00
2107	Томилолт, зочны зардал	3,630,100.00	2,807,500.00
210702	Дотоод албан томилолт	3,630,100.00	2,807,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,834,429.50	9,856,597.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,588,612.00	8,747,197.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	232,100.00	540,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	469,100.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	177,117.50	227,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	73,800.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	150,000.00	203,400.00
210807	Газрын төлбөр	138,300.00	138,300.00

Алдархаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	5,400.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,733,971.00	17,803,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,430,571.00	17,500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	303,400.00	303,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,030,148.47	33,245,181.70
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,878,900.00	25,602,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,878,900.00	25,602,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	14,151,248.47	7,643,181.70
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,151,248.47	7,643,181.70
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>981,429.00</u>	≡
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,650,000.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,650,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	1,650,000.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,650,000.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(1,650,000.00)</u>	≡
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(668,571.00)	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	668,571.00	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ЭЗА	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	352,529,600	345,086,438.30	-
21	УРСГАЛ ЗАРДАЛ	352,529,600	345,086,438.30	-
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	326,927,600	319,484,438.30	7,443,161.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	215,554,000	211,605,911.24	3,948,088.76
210101	Үндсэн цалин	215,554,000	211,605,911.24	3,948,088.76
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,099,800	25,635,227.06	3,464,572.94
210201	Тэтгэврийн даатгал	20,477,600	17,856,497.66	2,621,102.34
210202	Тэтгэмжийн даатгал	2,155,500	2,001,752.94	153,747.06
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,724,500	1,587,585.92	136,914.08
210204	Ажилгүйдлийн даатгал	431,100	377,724.54	53,375.46
210205	Эрүүл мэндийн даатгал	4,311,100	3,811,666.00	499,434.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49,177,400	49,177,400.00	-
210301	Гэрэл, цахилгаан	3,820,000	2,226,035.27	1,593,964.73
210302	Түлш, халаалт	45,357,400	46,951,364.73	(1,593,964.73)
2104	Хангамж, бараа материалын зардал	22,794,200	22,794,200.00	-
210401	Бичиг хэрэг	2,828,300	2,828,300.00	-
210402	Тээвэр, шатахуун	15,715,300	15,715,300.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,250,600	4,250,600.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,792,800	2,792,800.00	-
210604	Урсгал засвар	2,792,800	2,792,800.00	-
2107	Томилолт, зочны зардал	2,838,000	2,807,500.00	30,500.00
210702	Дотоод албан томилолт	2,838,000	2,807,500.00	30,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,868,000	2,868,000.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,758,600	1,758,600.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000	540,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	-	-	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227,700	227,700.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	203,400	203,400.00	-
210807	Газрын төлбөр	138,300	138,300.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,803,400	1,803,400.00	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,500,000	1,500,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	303,400	303,400.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,602,000	25,602,000	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,602,000	25,602,000.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,602,000	25,602,000.00	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	352,529,600	352,529,600.00	-
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	352,529,600	352,529,600.00	-
122005	Орон нутгийн төсвөөс	352,529,600	352,529,600.00	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Алдархаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	25,361,237	25,361,237
21	УРСГАЛ ЗАРДАЛ	25,361,237	25,361,237
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	25,361,237	25,361,237
2104	Хангамж, бараа материалын зардал	2,372,640	2,372,640
210402	Тээвэр, шатахуун	2,372,640	2,372,640
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,988,597	6,988,597
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,988,597	6,988,597
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,000,000	16,000,000
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,000,000	16,000,000
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	200,020	200,020
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	200,020	200,020
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	25,561,257	25,561,257
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	25,561,257	25,561,257
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	25,561,257	25,561,257

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Алдархаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл, тайлагнал, худалдан авалт, арвилан хэмнэлт зэрэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Оюунсүвд гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Б.Дагвасүрэн, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Алдархаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 03/27 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Алдархаан сумын Засаг даргын Тамгын газар нь “Төр засгийн бодлого шийдвэрийн хэрэгжилтийг оновчтой зохион байгуулж мэргэшсэн төрийн албан хаагчдаар төрийн албан хаагчдаар төрийн албыг бүрдүүлэн иргэдэд төрийн үйлчилгээг ил тод шуурхай тэгш хүртээмжтэй хүргэх” зорилго тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам, заавар зэргийг боловсруулж мөрдсөн.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алдархаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл

баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг нийт орлогоос 378.1 сая төгрөгөөс 1 хувиар буюу 3.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 буюу 2.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мян.төг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	-	26.8	26.8
Бараа материал	32,909.9	30942.8	-1,967.1
Үндсэн хөрөнгө	810,214.2	558,443.5	-251,70.7
Нийт хөрөнгө	843,124.0	589,413.1	-253,710.9
Өр төлбөр	2,006.3	5,584.2	3,577.9
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	841,117.8	583,828.9	-257,288.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	843,124.0	589,413.1	253,710.9

Бараа материалын дансны үлдэгдэл 1,967.1 мянган төгрөгөөр буурсан нь хангамжийн материал 967.1 мянган төгрөгөөр буурсан, мал амьтад 1,000.0 мянган төгрөгийн мал амьтад актлагдсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 251,770.6 мянган төгрөгөөр буурсан нь Ерөнхий боловсролын сургуулиас 200,164.9 мянган төгрөгийн барилгыг балансаас баланст шилжүүлэн авсан болон 375,918.2 сая төгрөгийн барилгыг Ерөнхий боловсролын сургуульд балансаас баланст шилжүүлсэн, мөн элэгдлийн зардал хасагдсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 257,288.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурсантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 352,529.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 352,259.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 352,529.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 345,086.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны байгууллагаас 25,561.3 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийн орлогыг бүрдүүлсэн байна.

Нэмэлт орлогын 25,361.2 мянган төгрөгийг урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцолсон болон бусад асуудал гараагүй.

3.8 Аудитын гол асуудал

4,518.9 мянган төгрөгийн шатахуун, 1,657.5 мянган төгрөгийн албан томилолтын зардлын зарцуулалтын баримыг бүрэн бүрдүүлээгүй, эдгээр зардлыг үрэлгэн зарцуулсан, 4,856.4 мянган төгрөгийн худалдан авалтын и-баримтыг бүрдүүлээгүй, улс төрийн албан хаагчид 2,899.9 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон, албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан ажлыг хавсран гүйцэтгүүлэхээр шийдвэр гаргаж, 590.6 мянган төгрөгийн нэмэгдэл хөлс олгосон, өмнөх онд үүссэн 2,006.3 мянган төгрөгийн түлш халаалтын өглөгийг барагдуулаагүй, тайлант онд 3,577.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 5,584.2 мянган төгрөгийн өглөг үүсгэсэн, нягтлан бодох бүртгэлээр тавих хяналт хангалтгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 145 мэдээллээс 135 мэдээллийг хугацаанд нь бүрэн оруулж, хугацаа хоцорсон мэдээлэл 10 байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ хэсэгт 140,849.7 мянган төгрөгийн орлого, 105,599.3 мянган төгрөгийн зарлагыг, Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр хэсэгт 5,584.2 мянган төгрөгийн өглөгийг, төсөв зарцуулахтай холбоотой шийдвэрийг мэдээлээгүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн “шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.5, 6.4.8 дахь заалттай нийцэхгүй байна” гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2,006.3 мянган төгрөгийн зөрчилд 1 заалт бүхий зөвлөмж өгсөн боловч зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Шатахууны зарцуулалт, бараа материалын дэлгэрэнгүй бүртгэлд анхаарах шаардлагатай байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 163,613.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 141,856.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 6,506.4 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 заалт бүхий зөвлөмж, 11,760.2 мянган төгрөгийн алдаа зөрчилд албан шаардлага хүргүүлж, улс төрийн албан хаагчид үр дүнгийн урамшуулал 2,899.8 мянган төгрөг, 2 албан хаагчид албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан ажлыг хавсран гүйцэтгэснээр нэмэгдэл хөлс 590.6 мянган төгрөг олгосон алдаа зөрчилд төлбөрийн акт тогтоосон. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 252,033.2 мянган төгрөгийн зөрчилд 1 заалт бүхий зөвлөмж хүргүүлсэн.

4.1 Залруулсан алдаа

Санхүүгийн байдлын тайланд 3,800.0 мянган төгрөгийн, үр дүнгийн тайланд 60,800.3 мянган төгрөгийн, мөнгөн гүйлгээний тайланд 12,388.5 мянган төгрөгийн, төсвийн гүйцэтгэлийн тайланд 7,843.2 мянган төгрөгийн, элэгдлийн зардал дутуу тооцсон 46,102.4 мянган төгрөгийн, бараа материалын тодруулгад 14,722.4 мянган төгрөгийн, нийт 145,656.8 мянган төгрөгийн алдаанд залруулга хийгдсэн.

4.2 Төлбөрийн акт

Улс төрийн албан хаагчид үр дүнгийн урамшуулал, 2 албан хаагчид албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан ажлыг хавсран гүйцэтгэснээр нэмэгдэл хөлс 3,490.4 мянган төгрөг тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.1 “улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцөлийн, докторын зэргийн нэмэгдлээс бүрдэнэ”, 57.1. “Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно”, Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2 “Ажилтан үндсэн ажлынхаа зэрэгцээ мэргэжил, ажил, албан тушаал хавсран буюу хослон ажилласан, эзгүй байгаа ажилтны үүргийг орлон гүйцэтгэсэн, ажлын байрны тодорхойлолтод заагаагүй ажил, үүргийг гүйцэтгэсэн, шөнийн болон илүү цагаар ажилласан бол үндсэн цалингаас нь тооцон нэмэгдэл хөлс олгоно” гэсэн заалтуудыг тус тус зөрчиж байна.

4.3 Албан шаардлага

Өмнөх оны аудитаар өгсөн түлш халаалтын 2,006.3 мянган төгрөгийн өглөгийг барагдуулах зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, тайлант онд тус өглөгийг 3,577.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 5,584.2 мянган төгрөгийн өглөг үүсгэсэн, 1,407.1 мянган төгрөгийн албан томилолтын зардлын зарцуулалтын баримтыг бүрэн бүрдүүлээгүй, 2,981.2 мянган төгрөгийн шатахууны зарцуулалтын баримт, тооцоо бодолт шаардлага хангаагүй, анхан шатны

баримтгүй 1,537.7 мянган төгрөгийн шатахуун, 250.0 мянган төгрөгийн албан томилолтын зардал гаргасан, нягтлан бодох бүртгэлээр тавих хяналт хангалтгүй байна.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

- ✓ 4,856.4 мянган төгрөгийн худалдан авалтын и-баримтыг бүрдүүлээгүй нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2; Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалтуудтай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдээдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"; Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ"; Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 "Албан татвар суутгаан төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатгаан нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ" гэсэн заалтуудыг мөрдөж ажиллах;:

2. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

- ✓ 2020 онд нийлүүлэгдсэн "Си-Ти-Эс" ХХК-ийн 1,650.0 мянган төгрөгийн өртөгтэй санхүүгийн программыг одоог хүртэл ашиглаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалт, УСНББОУС 17-той нийцэхгүй, тохиолдсон байх гэсэн батламж мэдээдлийг хангахгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

- ✓ "Си-Ти-Эс" ХХК-аас нийлүүлэгдсэн 1,650.0 мянган төгрөгийн өртөгтэй санхүүгийн программыг 2022 оны 03 дугаар сарын 01-ээс ашиглаж эхлэх, 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг тус программаар гаргах;

3. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

3.1 Илрүүлэлт:

- ✓ Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ хэсэгт 140,849.7 мянган төгрөгийн орлого, 105,599.3 мянган төгрөгийн зарлагыг, Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр хэсэгт 5,584.2 мянган төгрөгийн өрийг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3. "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", Шилэн

дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын 3.2.10. “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ бүрийг холбогдох шийдвэрийн хуулбарын хамт тухайн гүйлгээ хийгдсэнээс хойш 7 хоногийн дотор энэ журмын 9 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу цахимаар”, 3.2.11. “зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулсан гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг гарсан өдрөөс хойш 7 хоногийн дотор энэ журмын 10 дугаар хавсралтад заасан маягтын дагуу PDF форматаар” гэсэн заалтуудтай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдээдлийг хангахгүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь хэсэгт санхүүжилт болон түлш халаалт, шатахуун, тэтгэмж, бараа үйлчилгээний бусад зардал зэрэг 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй ажил гүйлгээг, 6.4.8 дахь хэсэгт төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг тухай бүр мэдээлж хэвших

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая. төг/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Алдархаан сумын ЗДТГ	8	163.6	4	141.8	1	3.5	1	11.8	2	6.5
Дүн		8	163.6	4	141.8	1	3.5	1	11.8	2	6.5
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
2	Алдархаан сумын ЗДТГ	1	252.0							1	252.0
Дүн		1	252.0							1	252.0
Нийт дүн		9	415.6	4	141.8	1	3.5	1	11.8	3	258.5